

МОНГОЛ УЛСЫН ЯЛЫН БОДЛОГЫН УЛАМЖЛАЛ БА ХОРИХ ЯЛ

TRADITION OF MONGOLIAN ACCUSATION POLICY AND IMPRISONMENT



Л.ХАШ

Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн эрх зүйн багш

KHASH L.

Legal Teacher at the Institute Of Finance and Economics

Товч агуулга: Монгол улсын ялын бодлого нь тухайн үеийн нийгмийн хамаарал ихээхэн нөлөөлсөн ба эрүүгийн хуулинд шууд зааж тусгагдсан бөгөөд эрүүгийн хуулийн зүйл заалт нь хатуу чанга хуульчлагдан батлагдаж хүний эрх, эрх чөлөөг хангах зүйл заалтууд тааруу байсан. 2002 оны Эрүүгийн хууль нь хүний эрхийн талаар тодорхой тусгагдсан боловч зүйл заалтууд нь хатуу шууд заасан хэлбэртэй болсон билээ. Ихэвчлэн ялын бодлого нь хорих ялд чиглэгдсэн мөн хорих байгууллагын тогтолцоо нь одоо хүртэл хуучин хэвэндээ байгаа нь гол асуудал юм. Судлаач миний бие нь хорих ялыг багасгах мөн нээлттэй хаалттай хорих байгууллагын асуудлыг хөндөхдөө түүхэн үүднээс судлан харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Ялын бодлогын уламжлал, Ялын бодлого, Хорих ял, ялын төрөл, ялын зарим асуудал

Abstract: Accusation policy of Mongolia had effected too much by social relationship reasons at the time. An accusation policy of Mongolia contained a lot of clauses of strict law. For the reasons, it's becoming difficult to secure human right issues.

The law of criminal procedure /Criminal law/ in 2002 had acquired many clauses about human right, unfortunately those clauses were too directly and inflexible. The main problem of accusation policy is still focusing on imprisonment and system of penal institution had no change. The aim of my research is to reduce the count of imprisonment and open-closed prison systems must be based on historical way.

Key words: Tradition of accusation policy, accusation policy of Mongolia, imprisonment, the types of accusation, other issues

Монгол улс нь 1924 онд үндсэн хуулийг бүх ардын хурлаар батлан гаргаж 1926 онд Монгол улсын анхны Эрүүгийн буюу БНМАУ-ын Шүүх цаазын бичиг гэсэн нэртэйгээр гаргаж байжээ.

- 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичигт ялын бодлогын талаар дараах байдлаар тодорхойлсон байна.

Аливаа ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчилан хамгаалах

арга зүйлүүдийг ялгаруулахуй нь: Ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчилан хамгаалах аргууд нь:

1. Алах ял
2. Гяндан хорьж албадан үйлдвэр хийлгэх
3. Гяндан хорихгүйгээр албадан үйлдвэр хийлгэх
4. Хөрөнгийг албан дор хураах
5. Тушаалаасаа огцруулах



буюу ямар нэгэн эрхэлж буй ажил үйлдвэрлэлийг хийхийг нь цаазлах

6. Мөнгөн ял торгох

7. Гадаад улсын харьяат нарыг хязгаараас үлдэн гаргах

8. Оноосон ялыг түдгэлзүүлэн, тэнсэн харгалзах

9. Шүүн таслах газраас донгодох

10. Хошууны зэрэг орон нутгийн захиргааны газар засаж залруулах тушаал өгөх

11. Биеийг албадан эмчлүүлэх

12. Аливаа эрхүүдийг бүрэн буюу эсхүл заримыг хугацаагаар буюу үүрд эвдэх¹

Хорих ял нэгэн өдрөөс 10 жил хүртэл тогтоох бөгөөд тэрхүү ялыг гяндан ба аливаа аж үйлдвэрийг хийлгэн сургаж засан сайжруулах газар хорьж дуусгана. Хорихгүйгээр үйлдвэр хийлгэх ялын хугацаа 100 өдрөөс үл хэтэрнэ.

Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүх таслах газраас тогтоосон 3-5 жил хүртлээс дээшгүй хугацааны дотор уг ялтан хүн дахин тэр мэтийн гэмт явдал эс үйлдвээс оноосон ялыг үл эдлүүлнэ. Хэрэв ялтан хүн шүүн таслах газраас тэнсэн тогтоосон хугацаа дуусахын өмнө дахин тэр гэмт явдлыг үйлдвээс шинэ хэргийн тухай оноосон ял дээр нь анхан оноож түдгэлзүүлсэн ялыг хамтатган хорих ба 10 жилийн хугацаанаас хэтрүүлж үл болно.²

Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах буюу аж үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ нь: Алба албан тушаалаас байлгах зэргээр ард олныг арчилан хамгаалах арга хэрэглэх дор 5 жилээс дээш бус хугацаа тогтоохоос гадна тийнхүү шийтгэх дор баримталваас зохих нь хууль дор тусгай заасан буюу эсвэл шүүх таслах азраас тэрхүү тушаалтныг оноосон тушаал дор хэвээр нь агуулах дор нь буюу эсвэл эрхэлсэн аж үйлдвэр нь ард олны байдал дор харштай болох зүйл бий аваас түүнийг тушаалаас буулгах буюу аж үйлдвэрийг цаазлах зэргээр нэмэгдүүлэх ял болгон тогтоовоос

зохино.

Сэтгэцийн өвчтэй хүнийг яллахдаа: Аливаа ял халдагсдыг шүүх таслах газар байцаах дор гэмт явдлыг үйлдсэн нь хуучин шийтгэсэн, ухаан балар өвчин буюу эсвээс ухаан төөрөлдөх шинэ өвчин олсон нь магад болох аваас түүнийг яллаж үл болох боловч сул тавьбаас бусад дор аюултай хэрэг гарахыг болзошгүй тул тусгай эмнэлгийн газар агуулж сувилбаас зохино.³

Гадны иргэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд: аливаа гадаадын хүн хэрэг халдваас тогтоосон хууль ёсоор яллахаас гадна хэрэв тэрхүү ялтныг тус улсын хязгаар дотор агуулахад сэжиглэлтэй харшлалтай зүйл буй аваас шүүх таслах газраас түүний биеийг дахин эргэж ирэхгүйгээр хязгаараас нэг мөсөн хөөн гаргахаар ялыг нэмэгдүүлэн тогтоож болно.

Эмэгтэй хүн гэмт хэрэгт холбогдсон бол: Эм хүнийг ялтнаас тусгай хорихоос гадна хэрэв бие нь жирэмсэн аваас төрөхийн урд хойно 3 сарын чөлөө олговол зохино.

Хуулинд заасан насанд хүрээгүй хүн: 11 наснаас 14 нас хүртэлх багачууд хөнгөн ял халдваас тэднийг эцэг, эх буюу итгэж бүхий хүмүүс нь хүлээн авсугай хэмээвээс даруй тушаан өгч сурган хүмүүжүүлж болох ба харин хүнд ял халдваас сайжруулах газар тушаан өгч сурган хүмүүжүүлвээс зохихоос гадна 15, 16, 17 насны залуус хэрэгт халдваас бусад ялтнаас тусад нь хорьж цээрлүүлэн шийтгэвээс зохино гэх мэт заасан байна.

- 1929 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичигт дараах байдлаар тодорхойлсон байна.

Ард улсыг арчилан хамгаалж засан сайжруулах арга зүйлүүдийг ялгаварлах нь.

Ард улсыг арчилан хамгаалж засан сайжруулах арга зүйлүүд нь:

1. Буудан алах

2. Хорих

3. Хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэх

4. Хөрөнгийг албан дор хураах

¹ БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. 1926.

² Д.Адьяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт". УБ., 1998.

³ БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. 1926.

5. Тушаалаас огцруулах ба ямар нэгэн эрхэлж буй ажил үйлдвэрээ хийхийг нь цаазлах

6. Мөнгө торгох

7. Оноосон ялыг түдгэлзүүлэн ялт хүмүүний байдлыг тэнсэх

8. Шүүх таслах газраас донгодох

9. Хошууны зэрэг орон нутгийн захиргааны газар засах залруулахаар тушаан өгөх

10. Биеийг нь албадан эмчлэх

11. Гадаад улсын харьяат нарыг хязгаараас үлдэн гаргах

12. Зарим нэг эрхийг хугацаагаар эвдэх⁴

Буудан алах ялыг үл хэлэлцэх этгээдүүд нь:

1. Анх гэмт явдал өдүүлсэн үест 18 насан дор хүрээгүй хүмүүст

2. Хөхүүл хүүхэдтэй буюу жирэмсэн бүсгүйчүүд нар болмой.

Хорих ялын тухайд: хорих ялыг 1 өдрөөс 10 жил хүртэл тогтоох бөгөөд тэрхүү ялыг засан сайжруулах газар эдлүүлэн дуусгах ба эрх биш албадан ажил, үйлдвэр хийлгэвээс зохимой. Хорихгүйгээр үйлдвэр хийлгэх ялын хугацаа нь 100 өдрөөс үл хэтэрмэй.

Хөрөнгө хураах: ялт хүмүүн хөрөнгийг улсын сан дор хураах дор хууль цаазан дор тусгай заасан буюу эсвэл тэрхүү гэмт явдлыг үйлдэж олсон нь үнэн болж илэрвээс уг хөрөнгийг бүрмөсөн буюу заримуудыг хураах ба түүний эм, хүүхэд, нэг хөрөнгөний хүмүүсийн амьдралын зүйл ба аж үйлдвэр дор чухал учир холбогдол бүхий зүйлүүдийг хичнээн үлдээх явдлыг цөм шүүх таслах газраас тогтоовоос зохимой.

Торгуулийн ял: торгуулийг төгрөгөөр тогтоож улсын ба орон нутгийн сан дор хурааваас зохимой. Үнэхээрийн ядуу хоосон этгээдийг 100 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр торгох бөгөөд хэрвээ уул зүйлийг төлөх хөрөнгө чинээ үгүй бол даруй хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэвээс зохих, үүн дор 1 өдрийн ажлыг 1 төгрөгөөр бодож гүйцэтгэхээс гадна торгуулийн зүйлийг хуваарилах буюу тогтоосон хугацааг тогтоол гаргасан өдрөөс эхлэн нэг жил

хүртэл сунгаж болмой.

Шүүх таслах газраас донгодохыг хөнгөн хэрэг дор хэрэглэмой. Хэрэв гэмт явдал үйлдсэн нь хөнгөн бөгөөд анх удаа хоосон ядуу ба боловсроогүй харгайгаар учрыг мэдэхгүй зэрэг учраас болсон аваас шүүх таслах газраас хэргийн байдлын нягталсны дараа тэрхүү хүмүүнийг хошууны зэрэг зохих албаны газар дор засан сайжиртал нэг жилээс дээш бус хугацаагаар тушаан өгч болмой.

Гадаадын иргэн ял үйлдсэн бол: аливаа гадаадын хүмүүн хэрэг халдваас тогтоосон хууль ёсоор яллахаас гадна хэрэв тэрхүү ялсныг тус улсын хязгаарын дотор агуулах дор хорлолтой харшлалтай зүйл буй аваас шүүх таслах газраас түүнийг биеийг дахин эргэж ирэхгүйгээр хязгаараас хөөн гаргах ялыг нэмэгдүүлэн тогтоовоос зохимой.

Эрх хязгаарлах ялын заалт: зарим нэгэн эрхийг хугацаагаар эвдэх хэмээсэн нь:

1. Сонгох, сонгогдох эрх

2. Аливаа сонгуулийн тушаалыг явуулах эрх

3. Ардын шүүн таслах газрын ардын төлөөлөгчийн албыг явуулах эрх

4. Уг газраас бус газар шилжин явах эрх

Энэхүү эрхүүдийг эвдэх явдал дор нэг жилээс 5 жил хүртэл хугацааг тогтоож болмой.⁵

- 1934 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичигт дараах байдлаар тодорхойлсон байна.

Шүүх цаазын бичиг зарласны зорилго нь: Шүүх цаазын бичиг зарласан нь ардын хувьсгалт засаг ба улс хийгээд тогтоосон эрх хэмжээнд харшлах олон нийт дор аюул бүхий хэргүүдээс хамгаалах зорилготой бөгөөд тийнхүү хамгаалахдаа уул үйлдсэн хүмүүст энэ шүүх цааз бичигт заасан ёсоор шийтгэх ялуудыг хэрэглэмой.

Шүүх цаазын бодлогын ерөнхий үүсэл. Эдүгээ оршин буй төрийн байгууллагын үндсийг тэрсэлсэн буюу эсвэл ардын хувьсгалт засгаас тогтоосон

⁴ БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. 1929.

⁵ Д.Адьяабазар. "Монгол улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил". УБ., 1998.

эрх хэмжээг зөрчин үйлдсэн буюу эс үйлдсэнээр олон нийтэд аюултай явдал үүссэнийг гэмт хэрэг гэнэ.

Ял шийтгэх явдлыг хэрэглэх зорилго.

1. Эхний хэрэг үйлдэгсдийг дахин гэмт хэрэг үйлдэхээр цээрлүүлэхийн тулд

2. Бусад тогтворгүй хүнд сануулга болгохын тулд

3. Гэмт хэрэг үйлдэгсдийг засруулах ажлаар оролдуулах журам байдал дор оруулах болмой.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүст ял хэрэглэж шийтгэж болох учрууд нь гагцхүү тэдгээр этгээдээс хэрэв:

1. Санаатай үйлдсэн нь энэ өдрийн үйлдлийн эцсийн болох зүйлийг мэдсэн ба түүнийг хүсэн гүйцэтгэсэн.

2. Боломжгүй үйлдэл нь энэ нь өөрийн үйлдлийн эцсийн болох зүйлийг мэдэх ёстой боловч үл мэдсэн ба эсвэл тэр мэт болох зүйлийг зайлуулж чадна хэмээн хөнгөмсгөөр найдсаны харгайгаар үйлдэгсэд сая эл шийтгэл болно.

Гэмт хэрэг үйлдсэн үед ухаан солиорсон ба өөр өвчний эрхээр чухам үйлдсэн нь эс ухамсарласан ба мөн тэрчлэн гэмт хэрэг үйлдэхдээ ухаан бүрэн агсан боловч харин таслан шийдвэрлэх тогтоол гарсан үед ухаан балартах өвчин гэнэт тохиолдвол ял шийтгэж үл болно.

Шийтгэх ялууд нь:

1. Буудан алах ял энэ нь ялын дээд хэмжээ

2. Хорих

3. Хорихгүйгээр албадан ажил хийлгэх

4. Улс төрийн эрхийг эвдэх ба хувийн зарим эрхийг эвдэх

5. Аливаа нэгэн орон нутгаас шилжүүлэн зайлуулах бөгөөд үүнд эль нэг орон нутагт оршин суухыг цаазлах ба үл цаазлах 2 янз байна.

6. Албан тушаалаас буюу эрхэлж буй ажлаас халах.

7. Донгодох ба олон нийтийн зүгээс буруушаан хэлэлцэх.

8. Хөрөнгийг бүтэн ба заримыг хураах

9. Мөнгөөр торгох

10. Учруулсан гэм хоруудыг арилгах үүргүүдийг даалгах

11. Улсын хязгаараас хугацаагаар ба үүрд үлдэн гаргах, үүнийг гадаадын харьяатанд хэрэглэнэ.⁶

Эмчлүүлэх чанартай хэрэглэх арга хэмжээнүүд

1. Албадан эмчлүүлэх

2. Ухаан солиорсныг зохих эмнэлгийн газарт шилжүүлэх

Буудан алах ял болвоос улсын хамгаалах онц хэмжээ мөн учир туйлын хүнд гэмт хэрэгт хэрэглэх бөгөөд басхүү шүүн таслах газраас ялтан этгээдэд мөнхүү гэмт хэрэг дахин үйлдэхийг цээрлүүлэх өөр аргагүй хэмээн бодсон буюу ард түмний дайсан этгээдийг айлган сүрдүүлэх онц чухал учир тохиолдсон тухайд хэрэглэнэ.

Хорих ба хорихгүйгээр албадан ажил хийлгэхийг зэрэгцүүлэн хэрэглэж үл болно. Шүүх цаазын бичгийн шийтгэх ялын 4, 5, 6, 10-д заасан шийтгэх ялуудыг бас хорих ял буюу хорихгүйгээр албадан ажил хийлгэх ялнууд дээр нэмэгдүүлэн хэрэглэх хэмжээ болгон зэрэгцүүлэн хэрэглэж болно. Хорих ялын хугацааг 1 сараас эхлэн 10 жилээс дээш бусаар тогтооно. Хэрэгт хүлээлгэн хорьсон ба таслан шийдвэрлэх тогтоол нь хуулийн хүчин төгөлдөр болтол хорьсон хугацааг уул шүүн таслах газраас тогтоосон хорих хугацаанд эрх биш оролцуулан тооцвоос зохино. Албадан ажил хийлгэхээр шийтгэгдэсдийг хорих хугацааны нэг өдрийг албадан ажил хийлгэх 3 өдөр тооцуулан бодож гүйцэтгэнэ. Хэдийгээр албадан ажил хийлгэх нь уул ял шийтгэгчдийг ажил үйлдвэрээр засан сайжруулах ба сахилга дэг журамтай болгохын тулд хэрэглэнэ. Хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг нэг 7 хоногоос 6 сар хүртэл тогтооно.⁷

- 1942 оны Эрүүгийн хуульд тусгагдсан байдал нь:

БНМАУ-ын Эрүүгийн хуулийн улс төрийн бодлогын ерөнхий үүсэл нь:

⁶ Бүгд найрамдах монгол ард улсын шүүх цаазын бичиг. 1934.

⁷ Д.Адьяабазар. "Монгол улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил". УБ., 1998.



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ



хувьсгалт төр эсэргүү хандсан буюу ардын хувьсгалт засгаас явуулсан хууль журмыг зөрчин үйлдсэн буюу эс үйлдсэнээр нийтэд аюултай явдлуудыг гэмт хэрэг гэнэ.

Ял шийтгэх зорилго нь.

1. Гэмт хэрэг үйлдэгчдийг дахин гэмт хэрэг өдүүлэхээс цээрлүүлэх
2. Нийгмийн бусад тогтворгүй хүмүүст сануулга болох
3. Гэмт явдал үлдэгчдийг засаж хүмүүжүүлэх шийтгэх ялын хэмжээ нь хүний бие махбодид зовоох буюу хүн гэсэн нэр зэргийг доромжлох зорилготой байж үл болно.

Гэмт хэрэг үйлдэгчдэд эрүүгийн хуулийн ёсоор оногдуулах ялын тухай.

Шүүх таслахын засан сайжруулах чанар бүхий арга хэмжээнүүд:

1. засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерьт байлгаж хорих
2. хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх
3. улс төрийн ба иргэний хувийн зарим эрхүүдийг хасах
4. аль нэгэн аймагт нутагт суухыг цаазалж тусгай заасан нутагт шилжүүлэн суулгах буюу эсвэл тийнхүү тусгай газрыг заахгүйгээр ямар нэгэн нутгаас зайлуулах
5. аль нэгэн тушаалыг эрхийг цаазлах буюу эсвэл цаазлахгүйгээр тушаалаас огцруулах
6. донгодох буюу олон нийтийн өмнө буруушаах
7. хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах
8. мөнгөн торгууль
9. учруулсан хохирлыг нөхөн гүйцэтгэх үүргийг даалгах
10. гадаадын харьяат нарт болбол БНМАУ-ын хилээс үлдэн хөөж болох⁸

Ялын дээд хэмжээ нь: Хувьсгалт төр засаг хийгээд улс нийтэд онц аюул бүхий хүнд гэмт хэргүүдтэй хатуугаар тэмцэхийн тулд энэхүү хуулийн зүйлүүдэд тусгайлан заасан байвал улс нийтийг хамгаалахын тулд туйлын арга болох буудан алах ялыг хэрэглэнэ.

Хорих ба хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөрийг хийлгэх

⁸ Монгол Улсын Эрүүгийн хууль. 1942.

явдал бол гэмт хэргийг үйлдсэн этгээд нарт ял оногдуулан хэрэглэвэл зохих шүүн таслахын үндсэн хэмжээнүүд мөн болно.

Эмчлүүлэх чанартайгаар хэрэглэх хэмжээнүүд нь

1. албадан эмчлүүлэх
2. тусгаарлаж хий судлын өвчнийг сувилах газар шилжүүлэх

Сурган хүмүүжүүлэх чанартайгаар хэрэглэх хэмжээнүүд нь.

1. насанд хүрээгүй багачуудыг хэрэв өргөн тэжээж чадах бол түүний төрсөн буюу үрчилсэн эцэг, эх, асран тэтгэх этгээд, ураг төрлийн хүмүүст шилжүүлэн өгөх, эсвэл өөр хүн буюу албан газар даалган харгалзуулах
2. сурган хүмүүжүүлэх тусгай газар шилжүүлэн хүмүүжүүлэх

Хорьж шийтгэх ялыг 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар шүүх таслах газраас тогтоох боловч эх орноос урвах, тагнуул хийх, хорлон сүйтгэх, тэсэж дэлбэлэх зэрэг гэмт хэрэг үйлдэгчдийг 25 жил хүртэл хорьж шийтгэнэ. Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэж ялыг 14 хоногоос нэг жил хүртэл хугацаагаар тогтоож уг ажиллаж байсан газар дээр нь ажиллуулах ба цалингийн 10-аас 25 хувийг суутган улсын орлого болгож байвал зохино. Ажилгүй байсан хүмүүсийг засан хүмүүжүүлэх газар шилжүүлнэ.⁹

- 1961 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан байдал:

Гэмт хэргийн ойлголт. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, түүний нийгмийн ба хөдөлмөр, эд хөрөнгийн болон бусад эрх, түүнчлэн хуулиар тогтоосон социалист хэв журамд хор хүргэсэн бөгөөд эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай хэргийг гэмт хэрэг гэж үзнэ. Нийгэмд аюултай гэмт хэрэг нь хүмүүсийн идэвхтэй ажиллагаа ба идэвхгүй байдлаар ч гарч болно.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийнхөө гэмт хэргийн нийгэмд аюултайг ухамсарлаж, түүнээс учирч болох хор хөнөөлийг урьдаас мэдсээр

⁹ Д.Адьяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил". УБ., 1998.



атал хүсэж үйлдсэн буюу эсвэл тэр хор хөнөөлд зориуд хүргүүлсэн бол санаатай үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийнхөө хэргийн нийгэмд аюултай хор хөнөөлд хүргэж болохыг урьдаас мэдсэн боловч тэр хор хөнөөлийг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсгөөр найдсан, эсвэл хор хөнөөл учруулна гэдгийг мэдэх ёстой бөгөөд мэдэх бололцоотой байсан атал мэдэлгүй үйлдсэн бол болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.

Ял шийтгэлийн зорилго нь: Ял шийтгэх явдал бол шийтгэгчдийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын ажил байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгон засаж хүмүүжүүлэх, тэрчлэн шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс ба бусад гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой. Ял шийтгэх явдал нь хүний бие махбодыг зовоох, хүн гэсэн эрийг доромжлон гутаах зорилгогүй.

Ял шийтгэл гэмт хэрэг үйлдэгсдэд доорх үндсэн ялыг оногдуулна.

1. Хорих
2. Нутаг зааж суулгах
3. Уг нутгаас зайлуулах
4. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
5. Ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох
6. Торгох
7. Олон нийтийн өмнө буруушаах¹⁰

Онцгой ял-цаазаар авах: Эх орноосоо урвах, тагнуул хийх, хорлон сүйтгэх ажиллагаа, алан хядах, хүндрүүлэх шалтгаантайгаар бусдыг санаатай алах, улс, олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах, иргэдийн амины хөрөнгийг хулгайлах, дээрэм хийх эдгээр гэмт хэргийн талаар хуульд тусгайлан заасан байвал онцгой ял цаазаар авах ял оногдуулж болно.

Хорих ялын талаар:

А. Хорих ялыг 6 сараас 10 жил хүртэл хугацаагаар тогтооно. Засан хүмүүжүүлэх ажлаас зайлсхийсэн этгээдийн ялыг хорих ялаар сольсон

¹⁰ Монгол Улсын Эрүүгийн хууль. 1961.

бол хорих ялыг 6 сараас доош хугацаагаар хэрэглэж болно. Эрүүгийн хуульд тусгайлан заасан байвал онцын хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж болно.

Б. Хорих ял шийтгэгдсэн нь уг ялаа засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони буюу гянданд эдэлж өнгөрүүлэх ба харин насанд хүрээгүй хүмүүс тусгай хүмүүжүүлэх колонид эдэлбэл зохино. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн ба удаа дараа шийтгэгдсэн этгээдийн эдэлбэл зохих ялыг бүгдийг нь буюу заримыг нь гянданд эдлүүлэхээр шүүхээс тогтоож болно. Гянданд хоригдох ялын тал хувиас доошгүйг эдэлсэн бөгөөд хүмүүжих төлөв олсон этгээдийн үлдэж байгаа ялыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр шүүх сольж болно. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид тогтоосон дэглэмийг хортой зөрчсөн этгээдийн засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлэх ялыг 3 жилээс дээшгүй хугацаагаар гянданд эдлүүлэхээр сольж үлдсэн ялыг хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр шүүх тогтоож болно.¹¹

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх: засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 1 сараас доошгүй, 1 жил 6 сараас дээшгүй хугацаагаар тогтоож, шийтгэгчийн ажиллаж байсан газар буюу оршин суугаа газарт нь ойролцоо өөр газар ажиллуулж, цалин хөлсний 10-аас 25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд зааснаар суутган авч улсын санд нийлүүлнэ. Хөдөлмөрийн чадваргүй этгээдэд оногдох засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг шүүхийн шийдвэрээр торгууль буюу олон нийтийн өмнө буруушаах ялаар солино.

Торгох ял: Хуульд заасан хэрэгт, хуульд заасан хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуулан авахыг торгууль гэнэ. Торгуулийн хэмжээг гэмт этгээдийн хөрөнгийн байдал, хэргийн хүнд хөнгөнийг харгалзан тогтооно. Торгууль төлөх хугацааг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш

¹¹ Монгол Улсын хуучин ба шинэ Эрүүгийн хуулиудын харьцуулсан судалгаа.

дээшгүйгээр тогтооно. Тогтоосон хугацаанд торгуулийг төлөхгүй бол шүүх торгуулийн 75 төгрөг бүрийг 1 сарын засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялаар сольж болох боловч 1 жил 6 сараас хэтрүүлж болохгүй.¹²

- 1986 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн Хууль

Гэмт хэргийн ойлголт: Бүгд найрамдах Монгол Ард Улсын нийгэм-эдийн засаг, төрийн байгууламж, социалист өмч, иргэдийн амь бие, эрүүл мэнд, улс төр, хөдөлмөр, эд хөрөнөнгийн болон бусад эрх, эрх чөлөө, түүнчлэн социалист эрх зүн өмчид халдсан бөгөөд эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай хэргийг гэмт хэрэг гэж үзнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл буюу эс үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.¹³

Гуравдугаар бүлэг: ялын зорилго

Ялын зорилго: ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх төдийгүй хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлыг социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болон засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино. Ял хүний бие махбодийг зовоох, алдар хүндийг гутаах зорилгогүй.

Ялын төрөл.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ялыг хэрэглэж болно.

1. Хорих
2. Нутаг заах
3. Уг нутгаас зайлуулах
4. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
5. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах
6. Торгох
7. Сахилгажуулах ангид явуулах
8. Олон нийтийн өмнө буруушаах

¹² Д.Адъяабазар. "Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт". УБ., 1998.

¹³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль. 1986.

9. Эд хөрөнгө хураах

10. Цэргийн болон тусгай алдар цолыг хасах

11. Онцгой ял-цаазаар авах

Хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, сахилгажуулах ангид явуулах, олон нийтийн өмнө буруушаах ялыг үндсэн ялын чанартай. Нутаг заах, уг нутгаас зайлуулах, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, торгох ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай. Эд хөрөнгө хураах, цэргийн болон тусгай алдар цол хасах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.

Хорих ял: Хорих ялыг зургаан сараас арван жил хүртэл, харин хүнд гэмт хэрэг, түүнчлэн онц хүнд хор уршиг учруулсан гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу онц аюултай рецидив гэмт хэрэгтэнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд арван таван жилээс дээшгүй хугацаагаар тогтооно. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд арван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй. Шүүн таслах шийдвэрлэх тогтоолоор хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид буюу гянданд, түүнчлэн жирийн болон чанга дэглэмтэй хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. Хүнд биш гэмт хэрэг санаатай үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн, хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу гэмт хэрэг болгоомжгүй үйлдэж хорих ял шийтгүүлсэн эрэгтэйчүүд, түүнчлэн төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн буюу онц аюултай рецидив гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна.



Хүнд биш гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэйчүүд, түүнчлэн хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. Урьд хорих ял эдэлж байсан буюу хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэйчүүдийн хорих ялыг чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна.¹⁴

2. 2002 оны Эрүүгийн хуулийн зүйл заалтуудад тусгагдсан байдал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино. Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно.

Гэмт хэргийн тухай ойлголт нь: Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг: Хөнгөн, Хүндэвтэр, Хүнд, Онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга

хэмжээ мөн.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна:

1. Торгох;

2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

3. Эд хөрөнгө хураах;

4. Албадан ажил хийлгэх;

5. Баривчлах;

6. Хорих;

7. Цаазаар авах.¹⁵

Торгох: Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 - 500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно. Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ялыг торгох ялаар солихыг хориглоно.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ялд нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол хугацааг нь үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.

Эд хөрөнгө хураах: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ноогдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ. Гэмт хэрэг

¹⁴ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг дугаар №6. УБ., 1987.

¹⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.



үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана. Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Албадан ажил хийлгэх: Эрүүгийн хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. Албадан ажил хийлгэх ял нь 100-500 цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож солино.¹⁶

Баривчлах: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ. Баривчлах ялыг 1 сараас 6 сар хүртэл хугацаагаар оногдуулна. Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван зургаан насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй.

Хорих: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ. Хорих ялын үндсэн хугацаа 1-10 жил хүртэл байна. Хорих ялыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар оногдуулж болно. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, 55-с дээш насны эмэгтэй, 60-с дээш насны эрэгтэйд 15 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй. Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.

Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтны хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтны хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтны хорих ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ. Хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтан, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

Урьд нь хорих ял эдэлж байсан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй эрэгтэй ялтны хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.¹⁷

Цаазаар авах: Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно. Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэх бөгөөд цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй гэж хуулинд заасан байдаг. Энэ нь нилээн хатуу эрүүгийн хууль болсон гэж зарим эрдэмтэд үздэг гэвч энэ асуудал нь тухайн үеийн нийгмийн байдалтай нягт холбоотой юм.

МОНГОЛ УЛСЫН ЯЛЫН БОДЛОГЫН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

1. Гэмт хэрэгт холбогдогчдын судалгаа

Анхан шатны шүүхүүд 2014 онд нийт 11430 хүнд холбогдох 7603 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 1430 хүнд холбогдох 712 хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 41 хүнд холбогдох 23 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 747 хүнд

¹⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.

¹⁷ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.



ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ

холбогдох 468 хэргийг хэрэгсэхгүй болгож, нийт 6375 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 8178 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан байна. Өнгөрсөн онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 3,3 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 1,4 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Ял шийтгүүлсэн нийт 8178 хүний 718 буюу 8,7 хувь нь эмэгтэй, 467 буюу 5,7 хувь нь насанд хүрээгүй этгээд, 23,4 хувь буюу 1919 хүнд урьд нь ял шийтгүүлж байсан, 19,3 хувь буюу 1582 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 5,5 хувь буюу 455 гэмт хэрэг давтан үйлдсэн байна.

Ял шийтгүүлсэн хүмүүсийг зарим бүлгээр авч үзвэл урьд ял шийтгүүлсэн хүн 1919 буюу 23,4 хувийг, гэмт хэрэг давтан үйлдсэн хүн 455 буюу 5,5 хувийг, бүлэглэж үйлдсэн хүн 1604 буюу 19,6 хувийг, согтуугаар үйлдсэн хүн 1582 буюу 19,3 хувийг, эмэгтэйчүүд 718 буюу 8,7 хувийг, насанд хүрээгүй этгээд 467 буюу 5,7 хувийг тус тус эзэлж байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн болон урьд ял шийтгүүлж байсан хүний тоо өсөх хандлагатай байна. Ял шийтгүүлэгчдийн дотроос ял шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 26 хүн буюу 3,8 хувиар, бүлэглэж үйлдсэн гэмт хэрэг 190 хүн буюу 13,4 хувиар, урьд ял шийтгүүлсэн хүний тоо 221 буюу 13 хувиар, өссөн бол гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний тоо 128 хүнээр буюу 7,5 хувиар, насанд хүрээгүй этгээдийн тоо 98 хүнээр буюу 17,3 хувиар тус тус буурсан байна.¹⁸

Хүснэгт 1: Ял шийтгүүлэгчид зарим бүлгээр

д\д	Утга	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Урьд ял шийтгүүлсэн	1698	1919	221	13
2.	Гэмт хэрэг давтан үйлдсэн	504	455	-49	-9,7
3.	Бүлэглэж үйлдсэн	1414	1604	190	13,4
4.	Согтуугаар үйлдсэн	1710	1582	-128	-7,5
5.	Эмэгтэй	692	718	26	3,8
6.	Насанд хүрээгүй этгээд	565	467	-98	-17,3

Шийдвэрлэсэн хэргийн төрөл: Өнгөрсөн онтой харьцуулбал анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэрээс хүнийг санаатай алах гэмт хэрэг 1,9 хувиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10,8 хувиар, танхайрах гэмт хэрэг 13,5 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 15,5 хувиар буурсан бол бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 20,7 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 12 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 20,7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2: Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

д\д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Он		Өсөлт, бууралт		Он		Өсөлт, бууралт	
		2013	2014	Тоо	Хувь	2013	2014	Тоо	Хувь
1.	Хүнийг санаатай алах	203	199	-4	-1,9	209	218	9	4,3
2.	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	265	320	45	20,7	270	330	40	20
3.	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	1283	1438	155	12	2077	2497	420	22,5
4.	Танхайрах	745	644	-101	-13,5	1134	958	-176	-15,5
5.	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	164	198	34	20,7	318	369	51	16

¹⁸ Шүүхийн нэгдсэн тайлан “Үнэлгээ, мониторинг”, “Эрүүгийн хэсэг”. 2015.



6.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	901	803	-98	-10,8	915	806	-109	-11,9
7.	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэг	58	49	-9	-15,5	70	74	4	5,7

Хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 11,9 хувиар, танхайрах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 15,5 хувиар тус тус буурсан бол хүнийг санаатай алах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 4,3 хувиар, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 16 хувиар, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 22,5 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20,2 хувиар, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргээр ял шийтгүүлэгчдийн тоо 5,7 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Оногдуулсан ялын төрөл: 2014 онд торгох ялаар 285, албадан ажил хийлгэх ялаар 442, баривчлах ялаар 1053, хорих ялаар 6277 хүн шийтгүүлсэн байна. Хорих ял шийтгүүлэгчдээс биечлэн эдлүүлсэн 2441, тэнссэн 3396, өршөөлд хамрагдсан 6 хүн байгаа бол насанд хүрээгүй 299 хүн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 135 хүнийг шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

Монгол Улс НҮБ-ын иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын цаазаар авах ялыг халахад чиглэгдсэн нэмэлт 2 протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор цаазаар авах ял шийтгүүлсэн хүн байхгүй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал шүүхээс баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 18 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 2,1 хувиар тус тус өссөн бол албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний тоо 52 хувиар, торгох ял шийтгүүлсэн хүний тоо 3,4 хувиар тус тус буурчээ.¹⁹

Хүснэгт 3: Оногдуулсан ялын төрөл

д\д	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Торгох	295	285	-10	-3,4
2.	Албадан ажил хийлгэх	466	442	-24	-5,2
3.	Баривчлах	1034	1053	19	1,8
4.	Хорих	6148	6277	129	2,1

Шүүхээс 2014 онд 285 хүнийг нийт 1 тэрбум 477 сая 241 мянга 600 төгрөгийн торгох ял, 502 хүнийг нийт 350 сая 666 төгрөгийн эд хөрөнгө хураах ялаар шийтгэж, тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах ялыг 244 хүнд, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 584 хүнд оногдуулжээ.


Хүснэгт 4: тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах, эд хөрөнгө хураах ял оногдуулсан хүн

д\д	Ялын төрөл	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Эд хөрөнгө хураах	405	502	97	24
2.	Тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах	92	244	152	165
3.	Тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах	586	584	-2	-0,3

Хорих ялын хугацаа: улсын хэмжээнд 2014 онд шүүхээс нийт 6277 хүнийг хорих ял шийтгэснээс 584 хүнд 1 жил, 2870 хүнд 1-3 жил, 1716 хүнийг 3-5 жил 677 хүнд 5-8 жил, 47 хүнийг 8-10 жил, 247 хүнийг 10-15 жил, 94 хүнийг 15-20 жил, 42 хүнийг 20-25 жилий хорих ялаар тус тус шийтгэсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулбал 20-25 жилийн хорих ял оногдуулсан хүний тоо өмнөх

оноос 20 хувиар, 15-20 жил хорих ялаар шийтгүүлсэн хүний тоо 1,1 хувиар тус тус өсжээ.



Хорих ялын дэглэм:

Анхан шатны шүүхээс 5479 хүн буюу 87,2 хувьд ялыг жирийн дэглэмтэй

хорих ангид, 756 хүн буюу 12 хувьд чанга дэглэмтэй хорих ангид, 39 хүн буюу 0,6 хувьд ялыг онцгой дэглэмтэй хорих ангид, 3 хүн буюу 0,06 хувьд ялыг гянданд эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Хорих ялын дэглэмийн төрлийг өмнөх онтой харьцуулбал жирийн дэглэмд хорих ялыг эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 1,9 хувиар өссөн бол чанга дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 0,8 хувиар, онцгой дэглэмд ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний тоо 17 хувиар тус тус буурсан байна.

Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг: нийт ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр авч үзвэл 14-15 настай ял шийтгүүлэгчид 134 буюу 1,6 хувийг, 16-17 настай ял шийтгүүлэгчид 353 буюу 4,3 хувийг, 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 буюу 48,7 хувийг тус тус эзэлж байна. Ял шийтгүүлэгчдийн дотор 18-29 настай ял шийтгүүлэгчид 3980 байгаа нь голлох хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 39 хүнээр буюу 1 хувиар, 35-аас дээш настай ял шийтгүүлэгчид 184 хүнээр буюу 0,8 хувиар тус тус өсжээ. Харин 14-15 настай ял шийтгүүлэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 72 хүнээр буюу 35 хувиар, 30-34 настай ял шийтгүүлэгчдийн тоо 32 хүнээр буюу 2,2 хувиар тус тус буурсан дүнтэй гарчээ.

Ял шийтгүүлэгчдийн боловсрол: нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 1102 буюу 13,4 хувь нь дээд, 2 буюу 0,02 хувь нь техникийн болон мэргэжлийн анхан шатны, 300 хүн буюу 3,6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3507 буюу 42,8 хувь нь бүрэн дунд, 1655 хүн буюу 20,2 хувь нь суурь, 997 хүн буюу 12,1 хувь нь бага боловсролтой, байгаа бол 615 буюу 7,5 хувь нь боловсролгүй хүмүүс байна. Ял шийтгүүлэгчдийг боловсролын

түвшингээр нь өмнөх онтой харьцуулж үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчийн тоо 15 хувиар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 49,8 хувиар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 4,8 хувиар тус тус өссөн бол бага боловсролтой ял шийтгүүлэгчид 1,7 хувиар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид 13,6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ял шийтгүүлэгчдийн эрхэлж байсан ажил, сургууль: нийт ял шийтгүүлсэн иргэдийн 61,1 хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй, 5 хувь нь оюутан, 3,8 хувь нь малчин, 2,8 хувь нь сурагч, 1,8 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 1,2 хувь нь төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн албан тушаалтан, 0,7 хувь нь төрийн тусгай албан хаагч, 0,4 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 0,28 хувь нь ялтан, 0,19 хувь нь улс төрийн албан тушаалтан, 0,13 хувь нь цэрэг байна. Нийт ял шийтгүүлэгчдээс эрхэлсэн ажил, сургуульгүй 5000 хүн байгаа бөгөөд нийт ял шийтгүүлэгчдийн 61,1 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1,3 хувиар өссөн дүн юм. Ял шийтгүүлсэн оюутан, сурагчдын тоо өмнөх оноос буурсан дүнтэй гарчээ. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлыг авч үзвэл амь хохирсон хүний тоо өмнөх оноос 71 хүнээр буюу 12,7 хувиар өссөн дүнтэй байна. Гэмт хэргийн улмаас 720 хүн хүнд, 853 хүн хүндэвтэр, 1443 хүн хөнгөн гэмтсэн бөгөөд өмнөх онтой харьцуулбал хүнд гэмтэл авсан хүний тоо 11,9 хувиар, хүндэвтэр гэмтэл авсан хүний тоо 30,5 хувиар, хөнгөн гэмтэл авсан хүний тоо 3,2 хувиар тус тус өсжээ.²⁰


²⁰ Шүүхийн нэгдсэн тайлан “Үнэлгээ, мониторинг”,



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ



МОНГОЛ УЛСЫН
ХҮҮЛЬД
ЯЛЫН
БОДЛОГО



Хүснэгт 5: Гэмт хэргийн улмаас амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол

Үзүүлэлт		Он		Өсөлт, бууралт	
		2013	2014	Тоо	Хувь
Амь бие, эрүүл мэндэд учирсан хохирол	Амь хохирсон	555	626	71	12.7
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон эмэгтэй	8	8	0	0
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь хохирсон насанд хүрээгүй этгээд	1	2	1	2 дахин
Гэмтэл	Хүнд	643	720	72	11.2
	Хүндэвтэр	653	853	200	30.6
	Хөнгөн	1397	1443	45	3.2

Улсын хэмжээнд 2014 шүүхийн шийдвэрлэсэн хохирлын нийт хэмжээ 78 тэрбум 169 сая 357 мянга 508 төгрөг байна. Үүнээс улсад учирсан хохирол 29 тэрбум 752 сая 216 мянга 6 төгрөг, аж ахуй нэгжид учирсан хохирол 27 тэрбум 14 сая 223 мянга 968 төгрөг, иргэдэд учирсан хохирол 21 тэрбум 402 сая 917 мянга 534 төгрөг байна.


2. Ялын бодлого ба хорих ялын талаарх цаашдын чиг хандлага

Хорих ял оногдуулалт, эдлүүлэлтийн талаар. 2002 оны Эрүүгийн хуульд ялын бодлого хэт өндөр буюу чанга хуульчлагдсанаас гадна хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах боломжгүйгээр хуульчлагдсан, мөн зарим тохиолдолд хорихоос өөр төрлийн ялыг сонгож оногдуулах боломжгүй /тухайн зүйл ангид заасан гэмт хэрэгт зөвхөн хорих ял оногдуулахаар заасан/-гээр тул хорих ял оногдуулалтын хэмжээ өмнөхөөс нэлээд нэмэгдсэн.

Хорих ял болон баривчлах ял нь зарчмын хувьд өөр төрлийн ялын төрөл (баривчлах ял нь хорихоос өөр төрлийн ял)-д хамаарах боловч ял эдлүүлж байгаа хэлбэрээрээ төдийлөн ялгагдахгүй байна. Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар баривчлах ялыг "гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлах байлгах замаар сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх" хэлбэрээр эдлүүлэх ёстой атал өнөөдөр Монгол Улсад энэхүү ялыг

хуульд заасан хэлбэрээр "ганцаарчлан" эдлүүлэхгүй, харин жирийн дэглэмтэй хорих ангид хорих ял эдлүүлэхтэй ижил хэлбэрээр олноор нь байлгаж, зарим орон нутагт хоригдлын хөдөлмөр эрхлүүлэх гэх мэт хэлбэрээр эдлүүлж байна. Энэ нь зарчмын хувьд хууль зөрчихөөс гадна хоригдлын эрхийг зөрчсөн хэрэг

"Эрүүгийн хэсэг". 2015.





болдог. Учир нь хорих ял эдэлж буй хоригдол хөдөлмөр эрхэлж, түүнийхээ хариуд цалин хөлс авах эрхтэй байдаг бол баривчлах ял эдэлж буй ялтан хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авах эрх зүйн зохицуулалт байхгүй, мөн уг ялтанд цалин хөлс тооцож, олгох механизм байхгүй. Гэтэл баривчлах ял эдэлж буй ялтнаар хөдөлмөр эрхлүүлж буй нь ялтны хөдөлмөрийг хууль бусаар мөлжиж буй хэрэг юм.

Ийнхүү хорих, баривчлах ялыг ялгамжгүйгээр эдлүүлэх, хорих ялыг илүү хэрэглэх нь шоронгийн хэт дүүргэлтийг бий болгож, зардлын өсөлт, эрүүл ахуйн нөхцөлийн бууралт, амьдрах нөхцөлийн хүндрэл, тогтоол гүйцэтгэх газрын ажилтнуудын хэт ачаалал зэрэг сөрөг үзэгдлүүдийн шалтгаан болох юм.²¹ Ийм учраас хорих, баривчлах ял нь төрөөс зардал шаардсан ял боловч ял эдэлж буй этгээд засарч хүмүүжихээс илүүтэй түгшүүртэй бөгөөд ямар нэг хэмжээгээр сэтгэл зүйн хямралд орсон байдаг учир үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүй байна.

Мөн баривчлах ял нь оногдуулах хугацааны хувьд ялгаатай болохоос биш ял эдлүүлэх хэлбэрээр хорих ялаас ялгагдах шинжгүй байдлаар хэрэгжиж байгаа нь учир дутагдалтай төдийгүй энэ асуудлыг онцгой анхаарах, зохих арга хэмжээ авах шаардлагыг бий болгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, баривчлах ялыг хуульд заасан зорилго, шаардлагын дагуу эдлүүлэх нөхцөл, боломжийг бий болгох шаардлагатай. Хэрэв баривчлах ялыг хуульд заасан зорилго, шаардлагад нийцүүлэн “хорих ял эдлүүлэх дэглэмээс хөнгөн тодорхой шаардлага бүхий дэглэмд ганцаарчлан” эдлүүлэх учиртайг анхаарах цаг болжээ. Иймээс эрүүгийн хуулийн талаар дахин нэг эргэн харах цаг нь болсон гэлтэй.

Хууль зүйл сайд Х.Тэмүүжин “Гэмт Хэргийн Хууль” хэмээх хуулийн төслийг улсын их хурлын байнгын хороонд өргөн барьсан бөгөөд тэрхүү танилцуулгад дурдсанаар Монгол Улсын эрүүгийн хуулийн төсөлд зорчих эрхийг хязгаарлах ялыг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан байна. Түүнчлэн тогтоосон замаар зорчих, хууль сахиулах байгууллагын

зөвшөөрлөөр оршин суух газраа өөрчлөх, шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хоригийг зөрчвөл уг ялын нэг хоногийг хорих ялын нэг хоногоор дүйцүүлэн тооцох юм байна. Энэ нь шинэ төрлийн ял бөгөөд шүүхээс хорих ялыг оногдуулах явдлыг багасгах зорилгоор электрон гавны тусламжтайгаар цахим хяналт тавих аж.

Хорих ял нь хугацаатай ба бүх насаар нь хорино гэсэн ангилалтай. Тухайлбал, хугацаатай хорих ял нь нэг сараас хорин жил хүртэл байх, бүх насаар хорих ял нь хорин жилээс дээш хугацаагаар байх бөгөөд суллагдах үндэслэл нь хорин жилээс дээш хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлсний дараа үүсэх аж.²²

ял шийтгэл хүлээлгэх насны хязгаарыг 14 наснаас байхаар зааж өгсөн байна. Энэ нь 14 наснаас дээш гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн бүрт ял оногдуулах зорилгогүй. Харин хүүхдийн хүмүүжил нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон ял шийтгэл оногдуулах, хүүхдийг аль болох хорих бус хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай сургалттай байгууллагад хүмүүжүүлэх. Хүүхдийн хууль зүйн хороо нь хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээнд хяналт тавих зэргээр тодорхой зохицуулалтыг тусгаж өгсөн байна.²³

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ юм. Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг. Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэрэгтнээс хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг, онц аюултай болон рецидив гэмт хэрэгтнүүдээс анх удаа

²² www.mass.mn

²³ Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор. “Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал” эрдэм шинжилгээний өгүүлэл. Хууль дээдлэх ёс сэтгүүл. 2006.

²¹ Хууль зүйн доктор, профессор Д.Зүмбэрэлхам. “ХБНГУ-ын Макс-Планкийн Их сургуулийн эрдэм шинжилгээний хурал дээр тавьсан илтгэл”. 2009.

гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг тусгаарлан ялыг эдлүүлэх зорилготой байдаг.

Өнөөгийн байдлаар насанд хүрээгүй хүн нь Сэжигтэн, яллагдагчийг Цагдан Хорих Шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан “Хорих Ангийн Дотоод журам”-аар заасан эрх зүйн орчинд насанд хүрэгчидтэй нэгэн адил нөхцөлд цагдан хоригдож, хорих ял эдэлж байна. Цаашид насанд хүрээгүй /хүүхдэд/ хүмүүсийн хорих ангийн дотоод журмыг тусгайлан гаргаж, мөрдөн ажиллах хэрэгтэй.

Монгол Улс нийгэм эдийн засгийн салбарт хийж буй зарим шинэчлэл, өөрчлөлтийг Евро стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд гадны улсын сайн туршлагыг зээлдэн авах, өөрийн хөрсөнд буулгах зэргээр бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Жишээ нь: ХБНГУ-ын Эрүүгийн хууль тогтоомж нь олон хууль (Эрүүгийн хууль, Ялын тухай хууль, Шоронгийн тухай хууль зэрэг)-иас бүрддэг. Ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц, нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнийг нээлттэй хаалттай төрөл дэглэмд ялгамжтай эдлүүлэх зорилгыг Ялын тухай хууль (1975 он) агуулсан байдаг. 1977 онд батлагдсан “Шоронгийн тухай” (Prison Act) хууль тус тус хамаарна. ХБНГУ-ын Шоронгийн тухай хуулийн зорилго нь хорих ялын нээлттэй хэлбэр ялтныг хэвийн амьдралд эргүүлэн оруулах, хуульд захирагдах, өөрийн үйлдлийн аливаа хариуцлагыг хүлээх, хэвийн ажиллаж амьдрахыг хангаж хариуцахад сургадаг. Энэ зорилгын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг байна.²⁴

Иймээс дараах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ:

1. Гадаадын зарим орны сайн хувилбарыг өөрийн хөрсөнд буулгаж “нутагшуулах”-даа ялтныг хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгосон, олон улсын стандартад нийцсэн байх шинжийг энэ тэргүүнд харгалзах;

2. Хоригдлын хөдөлмөрлөж хохирлоо нөхөн төлөх бололцоог хангах ажлыг зохион байгуулж, үүнд аж ахуйн

нэгж, байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах санхүүгийн болон бусад арга хөшүүргийг олох;

3. Анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах;

Эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд мөн хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх, Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах юм.

Зарим хөнгөн төрлийн гэмт хэрэгт анх удаа үйлдэж буй иргэн, ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийн эрх ашгийг бага хөндөх эсвэл хөнгөрүүлэх нөхцөл бололцоо бие болгох юм. Шинээр батлагдан гарч байгаа Монгол Улсын Гэмт Хэргийн тухай хуулийн зарим хэсэг нь: торгох, нийгэмд тустай ажил хийлгэх, эрх чөлөө хязгаарлах, хорих гэсэн ялын төрөлтэй. Хорих ял нь нээлттэй ба хаалттай гэсэн хэлбэртэй байгаа нь цаашид хорих байгууллагыг нээлттэй, хаалттай дэглэмийг ялган зааглах хэрэгтэй юм.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын хуулиуд

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх цаазын бичиг. 1926.
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх цаазын бичиг. 1929.
3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх цаазын бичиг. 1934.
4. Монгол Улсын Эрүүгийн хууль. 1942.
5. Монгол Улсын Эрүүгийн хууль. 1961.
6. Монгол Улсын Эрүүгийн хууль. 1986.
7. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.
8. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002.

2. Ном, сурах бичиг

1. Т.Сэнгэдорж. “Монгол Улсын

²⁴ УДШ, Ханнс-Зайделийн сан. Зохиогчдын хамтлаг. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”. 2010.

төр, эрх зүйн үндэс". УБ., 1998.

2. О.Жамбалдорж, С.Баасай. "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хуулиуд". УБ., 1980.

3. Д.Адьяабазар. "Монгол улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт". УБ., 1998.

3. Судалгааны тайлан

1. Монгол Улсын хуучин ба шинэ эрүүгийн хуулиудын харьцуулсан судалгаа.

2. УДШ, Ханнс-Зайделийн сан. Зохиогчдын хамтлаг. "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар". 2010.

3. Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор. "Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал" эрдэм шинжилгээний өгүүлэл. Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2006 оны №2. 73 дах тал

4. Д.Зүмбэрэллхам. "ХБНГУ-ын Макс Планкийн Их сургуулийн эрдэм шинжилгээний хурал дээр тавьсан илтгэл". 2009.

5. Шүүхийн нэгдсэн тайлан "Үнэлгээ, мониторинг", "Эрүүгийн хэсэг". 2015.

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн,

хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа Д.Мягмарцэрэн



Хууль сахиулахуй